



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

**ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
ШИВЭЭГОВЬ СУМЫН АРДЧИЛСАН
НАМД**

2020.08.10 № 217
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Шивээговь сумын Ардчилсан нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


“Шивээговь сумын Ардчилсан нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шивээговь сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр /...хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\2020\Alban toot.doc

0080200369



ШИВЭЭГОВЬ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2020-2024 ОНЫ

“ШИНЭХЭН ХОТ ШИВЭЭГОВЬ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Шивээговь сумын Ардчилсан нам нь 2020 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг 7 зорилт, 34 арга хэмжээний хүрээнд боловсруулсан.

Зорилт 1: Хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр

- 1.1. Хадлангийн хийх шаардлагатай багаж тоног төхөрөмжийн материаллаг баазыг нэмэгдүүлнэ. Өвс тэжээлийн фондны агуулах нөөцийг нэмэгдүүлж болзошгүй арга хэмжээг цаг алдалгүй авна.
- 1.2. Чинээлэг малчин хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ.
- 1.3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ
- 1.4. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ. /Худаг гаргах/

Зорилт 2: Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр

- 2.1. Сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.2. Соёлын төвийн барилгыг шинээр барьж, материаллаг баазыг бэхжүүлнэ.
- 2.3. Гэр хорооллын айл өрхийг цэвэр, бохирын шугамтай холбосноор иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдэнэ.
- 2.4. Сумын цэвэрлэх байгууламжыг шинээр байгуулах
- 2.5. Сумын төв болон улсын чанартай авто замыг хатуу хучилттай замаар холбох
- 2.6. Төрийн байгууллагуудын байрыг үе шаттайгаа засварлах
- 2.7. Илчлэг Шивээ ОНӨҮГ-ын зуухыг бүрэн шинэчлэж, хэрэглээний халуун хүйтэн усаар тасралтгүй жилийн 4 улиралд хангана.
- 2.8. Тээвэр ложистикийн цогцолбор байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- 2.9. Иргэдэд өмчлүүлсэн газарт цахилгааны эх үүсвэрийг бүрэн шийднэ.
- 2.10. Цахим сум хөтөлбөр

0000000001



Зорилт 3: Эрүүл мэндийн чиглэлээр

- 3.1. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, иргэд эрүүл мэндийн шалтгаанаар санхүүгийн эрсдэлд орохгүй байхаар эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог түргэн шуурхай болгох.

Зорилт 4: Боловсролын чиглэлээр

- 4.1. Сургууль цэцэрлэгийн орчинг тохижуулан, камержуулж, гэрэлтүүлэгийг нэмэгдүүлж суралцанчдын суралцах нөхцөл бололцоог сайжруулна.
- 4.2. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
- 4.3. Малчин өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 5: Байгаль орчин

- 5.1. Сумын төвлөрсөн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлж шинээр байгуулах
- 5.2. Өрх бүр 1 мод хөтөлбөр
- 5.3. Эко сум хөтөлбөр
- 5.4. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулж, иргэд хогоо ангилан ялгаж тушаах

Зорилт 6: Засаглалын бодлого

- 6.1. Стандарттай сум хөтөлбөр
- 6.2. Хот, хөдөөгийн иргэдээ зээлийн хөнгөлттэй нөхцлөөр хувийн орон сууцтай болгоход төрийн бодлогоор дэмжинэ.
- 6.3. Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт болон хот, хөдөөд эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход түлхүү чиглүүлэх бодлого баримтална.
- 6.4. Төрийн албанаас бизнесийн салбарт шилжиж баялаг бүтээх иргэдийнхээ бизнесийн эхлэлтийн хөрөнгө оруулалтыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлдэг журамд шилжинэ.
- 6.5. Ган, эрчим хүч коксын цогцолбор байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

00000000002



6.6. Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэсэн цахилгаан станц барихад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

6.7. Тээвэр ложистикийн цогцолбор байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

6.8. Хууль бус лицензүүдийг цуцлуулж, орон нутгийн өмчит уурхайг байгуулах ажлыг бодлогоор дэмжин сумын иргэн бүрт хувьцаа эзэмшүүлнэ.

Зорилт 7: Нийгмийн бодлого

7.1. Хүүхэд залуудчын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг үргэлжилүүлэн хэрэгжүүлнэ.

7.2. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих дэд хөтөлбөрийг үргэлжилүүлэн хэрэгжүүлнэ.

7.3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг үргэлжилүүлэн хэрэгжүүлнэ.

ШИВЭЭГОВЬ СУМЫН

АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА *Ж.Батмөнх* Ж.БАТМӨНХ



0000000003

Ж.Батмөнх *Ж.Батмөнх* *Ж.Батмөнх*